

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН  
ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**АУДИТЫН КОД: САГ-2018/25/СТА-ТЕЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер С.Оюунгэрэл  
Утас: 261885 Цахим хаяг: [oyungerels@audit.gov.mn](mailto:oyungerels@audit.gov.mn)

Ахлах аудитор Д.Цэрэндорж  
Утас: 261740 Цахим хаяг: [tserendorjd@audit.gov.mn](mailto:tserendorjd@audit.gov.mn)

Аудитор Ц.Энхжаргал  
Утас: 261740 Цахим хаяг: [enkhjargalts@audit.gov.mn](mailto:enkhjargalts@audit.gov.mn)

Аудитор Б.Энхжин  
Утас: 261740 Цахим хаяг: [enkhjinb@audit.gov.mn](mailto:enkhjinb@audit.gov.mn)

Улаанбаатар хот



## АГУУЛГА

1	Аудитын хураангуй тайлан .....	2
2	Аудитын гэрчилгээ .....	5
3	Аудитын тайлан .....	7
3.1	Оршил .....	7
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	7
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	8
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
3.5	Дотоод аудит.....	10
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
3.7	Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	12
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	12
3.9.1	Мөнгөн хөрөнгийн талаар.....	13
3.9.2	Авллага, өглөгийн талаар.....	13
3.9.3	Үндсэн хөрөнгийн талаар .....	13
3.9.4	Үндсэн хөрөнгийн үнэлгээний талаар.....	14
3.9.5	Санхүүгийн тайлагналын талаар .....	14
3.9.6	Эргэн төлөгдөх зээлийн талаар .....	14
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	15
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд .....	15
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	15
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	16
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	16
3.16	Үр өгөөжийн тооцоолол .....	17
4	Менежментийн захидал.....	18
4.1	Мөнгөн хөрөнгийн талаар.....	19
4.2	Үндсэн хөрөнгийн үнэлгээний талаар.....	20
5	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	21
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	21
5.2	Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	22
5.3	Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	23
5.4	Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	24
5.5	Төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан .....	25
6	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	28
7	Албан шаардлага.....	31



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН САЙД, УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ГИШҮҮН Ц.ЦОГЗОЛМАА  
ТАНАА

2018.04.25 № 1043

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна. Иймд "хязгаарлалттай" санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

110.10.10.2018.04.25.1043

070477

## Аудитын гол асуудал

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд

- Нийт 163,722.2 сая төгрөгийн авлага өглөгийн тооцоог нийлж, актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "тасралтгүй", 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах",
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол шийдвэргүйгээр 22,827.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэж, 2,388.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.4-т "... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх ... саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэж заасныг тус тус зөрчсөн нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

\\10.10.10.20\Bosq\_kheregi\Year55\_2017\27819\2017\03\12\2017

### 3 АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1 ОРШИЛ

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайд Ц.Цогзолмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд тус Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, **аудит хийгдсэн** санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн үнэлгээний талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

#### 3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 15-наас 2018 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн



ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж, аудитор Ц.Энжаргал, Б.Энхжин нар хариуцаж хэрэгжүүлэв.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 1а/3109 дүгээр албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

### **3.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар тогтоосон дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролын сургалтын чанарыг дээшлүүлэх, өрсөлдөх чадвартай хүний нөөц бэлтгэх, багш бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх;
- Боловсролын чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг сайжруулах, насан туршийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг шинэчлэх, өргөжүүлэх;
- Шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийн бодлого, судалгааны боловсруулалтын ажлын нийгэм, эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлж, улс орны хөгжил, нийгмийн сайн сайханд чиглүүлэх;
- Хувь хүний хөгжил, нийтийн соёлыг дэмжсэн соёл, урлагийн олон талт үйлчилгээг нийгэмд хүртээмжтэй хүргэж чадахуйц өрсөлдөх чадвар бүхий тогтвортой, хариуцлагатай, үр ашигтай үндэсний үйлчилгээний тогтолцоо, соёлын өвийн хамгаалал, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бэхжүүлэх;
- Судалгаанд суурилсан биеийн тамир, спортын олон талт үйлчилгээг нийгэмд хүртээмжтэй хүргэж чадахуйц өрсөлдөх чадвар бүхий тогтвортой, хариуцлагатай, үр ашигтай үндэсний биеийн тамирын үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэх, бэхжүүлэх;
- Салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын удирдлагын манлайллыг хангах, яамны төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын чадавхийг сайжруулах, байгууллагын соёл төлөвшүүлэх, салбарын мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын болон яамны үйл ажиллагааны дотоод аудит, хяналт-шинжилгээ үнэлгээг чанаржуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, боловсролын хяналтыг хяналт-шинжилгээ, тандалт, судалгаа хийх хэлбэрээр хэрэгжүүлэх зэрэг болно.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам нь дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.


Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам нь тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 8 арга хэмжээ төлөвлөснийг хүснэгтээр харуулбал:



Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний  
байгууллагуудын 2017 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрсэн үр дүнгийн талаарх  
чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

Хүснэгт №1

		Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2017 оны зорилтот түвшин	2017 онд хүрсэн түвшин	Хувь
<b>24.1</b>	<b>Сургуулийн өмнөх боловсрол</b>				
	24.1.1	Суралцах хүүхдийн тоо	229,470	233,015	101.5
	24.1.2	Хүүхдийн цэцэрлэгийн тоо	1,371	1,416	103.3
	24.1.4	Хамран сургалтын хувь	86.8	86.1	99.2
	24.1.9	Төрийн бус өмчийн цэцэрлэгийн тоо	503	538	107.0
	24.1.10	Төрийн бус өмчийн цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо	23,547	36,671	155.7
<b>24.2</b>	<b>Тусгай хэрэгцээт боловсрол</b>				
	24.2.1	Тусгай хэрэгцээт боловсрол /хөгжлийн бэрхшээлтэй/ хамрагдах цэцэрлэг, сургуулийн хүүхдийн тоо	2,612		
<b>24.3</b>	<b>Ерөнхий боловсрол</b>				
	24.3.1	Суралцах хүүхдийн тоо	559,223	548,708	98.1
	24.3.2	Ерөнхий боловсролын сургуулийн тоо	808	803	99.4
	24.3.3	Хамран сургалтын хувь	94.0	94.0	100.0
	24.3.4	Дотуур байранд хамрагдах хүүхдийн тоо	41,382	38,444	92.9
	24.3.5	Үдийн цай хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо	256,471	309,355	120.6
	24.3.6	Төрийн бус өмчийн сургуулийн тоо	144	146	101.4
	24.3.7	Төрийн бус өмчийн сургуульд хамрагдах хүүхдийн тоо	28,341	33,056	116.6
<b>24.4</b>	<b>Насан туршийн болон албан бус боловсрол</b>				
	24.4.1	Албан бус боловсролд хамрагдах хүүхдийн тоо	11,740	8,648	73.7
<b>24.5</b>	<b>Дээд боловсрол</b>				
	24.5.1	Их, дээд сургуулийн тоо	100	96	96.0
	24.5.2	Дэлхийн шилдэг сургуульд суралцагчийн тоо	225	191	84.9
	24.5.6	Багш инженерийн чиглэлийн суралцагчдаас сургалтын төлбөрийн хөнгөлөлтөнд хамрагдсан суралцагчийн тоо	1,954	1,817	93.0
	24.5.7	Багшлах дадлагад хамрагдсан суралцагчийн тоо	1,762	704	40.0
<b>24.6</b>	<b>Шинжлэх ухаан, технологи</b>				
	24.6.1	Эрдэм шинжилгээний үндсэн судалгаанд зарцуулах зардлын эзлэх хувь	32.0	32.0	100.0
	24.6.2	Хэвлүүлсэн шинжлэх ухааны бүтээлийн тоо	10,500	11,901	113.3
	24.6.3	Үйлдвэрлэлд шилжүүлсэн технологийн тоо	305	209	68.5
<b>24.7</b>	<b>Соёл урлаг</b>				
	24.7.1	Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн тоо /хүн амд эзлэх хувиар/	75.0	74.0	98.7
	24.7.2	Нийтийн номын сангийн байнгын уншигч /хүн амд эзлэх хувиар/	15.0	15.0	100.0
	24.7.3	Жилийн эцэст хүрсэн байх музейн үзмэрийн тоо /мянгаар/	280.0	278.0	99.2
	24.7.4	10000 хүнд ногдох номын тоо /мянган ширхэг/	30.0	28.0	93.3
	24.7.5	10000 хүнд ногдох соёлын төвийн суудлын тоо	350	345	98.6
<b>24.8</b>	<b>Биеийн тамир, спорт</b>				
	24.8.1	Нийтийн биеийн тамираар хичээллэгчийн тоо /хүн амд эзлэх хувиар/	40.0	23.7	59.3
	24.8.2	Олон улсын болон тив, дэлхийн чанартай тэмцээнээс авсан медалийн тоо	100	116	116.0



Эх сурвалж: Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны нэгтгэсэн тайлан

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

### **3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамнаас тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д тэмдэглэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 11 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

### **3.5 Дотоод аудит**

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийх чиг үүргийг гүйцэтгэж байна.





Хүснэгт 2. Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	2	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	3	
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	3	
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	
		Дүн (сая.төг)	1.4
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	
		Дүн (сая.төг)	1.4
6	Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын	Тоо	-
		Дүн (сая.төг)	-

Эх сурвалж: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2017 онд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийсэн ажлын тайлан

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд давтан илэрч байна.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

### 3.6 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар сургуулийн өмнөх боловсрол, тусгай хэрэгцээт боловсрол, ерөнхий боловсрол, насан туршийн болон албан бус боловсрол, дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи, соёл урлаг, биеийн тамир, спортын хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.


Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 1,322,550.3 сая төгрөгийг баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 6.5 хувь буюу 86,131.7 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харахад бараа үйлчилгээний бусад зардал батлагдсан төлөвлөгөөнөөс 35.3 хувиар буюу 3,605.8 сая төгрөгөөр хэтэрч, бусад зардлууд бүлгийн дүнгээр хэмнэсэн байна.

Төлөвлөснөөс улсын төсвийн санхүүжилт 50,996.8 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 28,483.6 сая төгрөгөөр, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих 1,102.1 сая төгрөгөөр тус тус дутуу байгаагаас зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 6.1 хувиар буюу 80,582.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн төрийн аудитын байгууллага бүрэлдэхүүн тайлангуудыг бүрэн бэлтгэсэн байна.



### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайд, Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна. Үүнд:

1. Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
3. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр;
4. Орлого /үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого/;
5. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл;
6. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;
7. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;
8. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн;
9. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт зэрэг болно.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудтай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

### 3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар


Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

### 3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Засгийн газрын тусгай сан 3, төвлөрүүлэн захирагчийн 1, төсвийн шууд захирагчийн 88, төрийн өмчит аж ахуйн нэгж 12, төсөл, хөтөлбөрийн нэгж 2, аудитын түүвэрт 104, аудитад хамрагдаагүй 14 байгууллагын, нийт 224 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т заасны дагуу 10 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 77 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт, 16 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 2 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт, 1 байгууллагад санал дүгнэлт өгөхөөс татгалзаж, 14 байгууллагын санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй, 104 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрлэлтэд хамруулсан.



### 3.9.1 Мөнгөн хөрөнгийн талаар

Харилцах дансан дахь 30,477.5 сая төгрөгийг дансны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй, арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн 82.5 хувь буюу 110,152.7 сая төгрөг Төрийн өмчийн 4 их, дээд сургуулийн харилцах дансанд байршиж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”,

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.4-т “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох”, 16 дугаар зүйлийн 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, анхан шатны баримт бүрдлийг үнэн зөв бүрдүүлж, цаашид алдааг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэх.

### 3.9.2 Авлага, өглөгийн талаар

2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 163,722.2 сая төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй. Үүнд:

- ✓ Авлагын 83.5 хувь буюу 162,210.3 сая төгрөг,
- ✓ Өглөгийн 8.8 хувь буюу 1,511.9 сая төгрөг байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “тасралтгүй”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, авлага, өглөгийг улирал бүрийн эцэст тооцоо нийлж, баталгаажуулах, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах талаар албан шаардлага хүргүүлэх.

### 3.9.3 Үндсэн хөрөнгийн талаар

Тайланд онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол шийдвэргүйгээр 22,827.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэж, 2,388.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан байна. Тухайлбал: 2013, 2014 онд яамны хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжаар бэлтгэсэн ШУТИС-ийн Эрдэмнэт сүлжээний төвд ашиглаж байсан гэх 13,008.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тушаал, шийдвэргүйгээр оны эцэст шилжүүлэн авсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.4-т “... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх ... саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудалд эрхэлсэн төрийн захиргааны төрийн аудитын байгууллагаг шээрл авах”,



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, ... шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг дагаж мөрдөж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх.

### 3.9.4 Үндсэн хөрөнгийн үнэлгээний талаар

Буянт-Ухаа спорт цогцолборын 24,048.4 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй барилга байгууламжийг тайлант онд “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК-иар 3,157.6 сая төгрөгөөр үнэлгээ хийлгэж, төрийн өмчийг үнэгүйдүүлсэн байна.

Төрийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн тооллого, дахин үнэлгээ 2009 оноос хойш хийгдээгүй бөгөөд Төрийн өмчит аж ахуйн нэгжид хөрөнгийг дахин үнэлүүлэх талаар аудитын компани зөвлөмж хүргүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 193 дугаар тогтоолын 1-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ...” гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраар хяналт хийлгэж, шийдвэрлэн ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

### 3.9.5 Санхүүгийн тайлагналын талаар

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 224 санхүүгийн тайлан нэгтгэгддэг бөгөөд 106 байгууллага тайлан ирүүлэхээс 63 төсвийн шууд захирагч, төрийн өмчит аж ахуйн нэгж, төсөл хөтөлбөрийн нэгж Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлээгүй, мөн 14 байгууллагын санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй байна. Тухайлбал: Боловсролын магадлан итгэмжлэгдсэн үндэсний зөвлөл, Хөдөө аж ахуйн техникийн шинжлэх ухаан, технологи үйлдвэрлэлийн нэгдэл, 12 төсөл, хөтөлбөрийн нэгжүүд байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж ...”, 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж ...” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангаа цаглабарт хугацаанд ирүүлээгүй болон аудит хамрагдаагүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэх.

### 3.9.6 Эргэн төлөгдөх зээлийн талаар

Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад магистр, докторын сургалтыг дүүргэсэн 555 төгсөгчийн сургалтын зээлийн төлбөр 15,364,723 ам.долларын буюу 37,292.2



сая төгрөгийг, дэлхийн шилдэг сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцсан 40 төгсөгчийн сургалтын зээлийн төлбөр 5,607,555.1 ам.доллар буюу 13,610.3 сая төгрөгийг санхүүжүүлснээс суралцагчид гэрээнд заасан зээлийн төлбөрийг төлөөгүй, Боловсролын зээлийн сан нь гэрээнд хяналт тавьж ажиллах үүргээ биелүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ...”, 20.2.6-д “... тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх тухай гэрээний 3.5-д “Их сургуулиа төгсөж ирсэн даруйдаа энэ тухай Сургалтын төрийн санд ирж мэдэгдэнэ”, 3.6-д “Төгсөгч ... зээлийн эргэн төлөх хуваарь гарган ... эргэн төлнө”, Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний 3.6-д “Их сургуулиа төгсөж эх орондоо ирснээс хойш ажлын 21 хоногийн дотор Сургалтын төрийн санд өөрийн биеэр ирж мэдэгдэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний заалтуудыг биелүүлэн, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж барагдуулах ажлыг зохион байгуулах талаар Боловсролын зээлийн санд албан шаардлага хүргүүлсэн байна.

### 3.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

- Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд 224 байгууллага нэгтгэгдсэнээс 104 байгууллага аудитын түүвэрт хамрагдсан бөгөөд 1,082,410.7 сая төгрөгийн төсвийн гүйцэтгэлтэй 18 нэгжийн санхүүгийн тайланг Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, нэгдсэн төсвийн ерөнхий нягтлан бодогч нар гарын үсэг зурж, төсвийг захиран зарцуулж байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийг үндсэн зарчмын дагуу тайлагнах, хяналт тавих шаардлага хангагдахгүй байна.
- Арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн 82.5 хувь буюу 110,152.7 сая төгрөг нь Төрийн өмчийн их, дээд сургуулийн харилцах дансанд байршиж байна.

### 3.11 ЗАВСРЫН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд дараах чиглэлээр нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:


- Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагууд
- Сайдын хөтөлбөр арга хэмжээний зардал

### 3.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 533,912.3 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, баталгаажуулав.

Үүнээс, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон энэ хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 332,712.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 188,924.7 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгч, 143,787.8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 2 зөвлөмж хүргүүлээ.

Нэгтгэлд хамрагдсан харъяа 96 байгууллага, аж ахуйн нэгж, төсвийн гэрээнд үзэн болон шууд захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 201,199.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс аудитаар 10,765.7 сая төгрөгийн алдааг залруулж, 81.5 сая



төгрөгийн зөрчлийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр 29 төлбөрийн акт тогтоож, 115,827.4 сая төгрөгийн зөрчилд 49 албан шаардлага өгч, 74,525.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 246 зөвлөмж хүргүүлсэн байна.

### 3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 6 зөвлөмж хүргүүлсний 1 зөвлөмж хэрэгжиж, 2 зөвлөмж хэрэгжээгүй, 3 зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжгүй талаарх тайлбарыг Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 1а/11424 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

### 3.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 1,387,940.5 сая төгрөг бөгөөд 1.0 хувь буюу 13,879.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

### 3.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ


Бид Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд

- Нийт 163,722.2 сая төгрөгийн авлага, өглөгийн тооцоог тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “тасралтгүй”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...”, 20.2.6-д “... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”,
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол шийдвэргүйгээр 22,827.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэж, 2,388.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.4-т “... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх ... саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах” гэж заасныг тус тус зөрчсөн нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Энэ нь УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, зөвөр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлийн хувьд



Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна. Иймд “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 2 дугаар хэсэгт үзүүлэв.

### **3.16 Аудитын үр өгөөжийн талаар**

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 188,938.5 сая төгрөгийн үр өгөөжийн тооцооллыг хийж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлагаар баталгаажуулсан болно.



#### **4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.





#### 4.1 МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЛААР

#### ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2

##### ҮАГ-ын ажиглалт

Харилцах дансан дахь 30,477.5 сая төгрөгийг дансны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй,

Арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн 82.5 хувь буюу 110,152.7 сая төгрөг Төрийн өмчийн 4 их, дээд сургуулийн харилцах дансанд байршиж байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”,

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

##### Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөж, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, төсвийн хөрөнгө үр ашиггүй байх, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх;

##### ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, анхан шатны баримт бүрдлийг үнэн зөв бүрдүүлж, цаашид алдааг давтан гаргахгүй байх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

##### Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**4.2 Үндсэн хөрөнгийн үнэлгээний талаар**

**ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2**

**ҮАГ-ын ажиглалт**

Буянт-Ухаа спорт цогцолборын 24,048.4 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй барилга байгууламжийг тайлант онд “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК-иар 3,157.6 сая төгрөгөөр үнэлгээ хийлгэж, төрийн өмчийг үнэгүйдүүлсэн байна.

Төрийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн тооллого, дахин үнэлгээ 2009 оноос хойш хийгдээгүй бөгөөд Төрийн өмчит аж ахуйн нэгжид хөрөнгийг дахин үнэлүүлэх талаар аудитын компани зөвлөмж хүргүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 193 дугаар тогтоолын 1-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ...” гэж заасантай нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд**

Хөрөнгө үнэгүйдэх, шамшигдах, Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

**ҮАГ-ын зөвлөмж**

Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраар хяналт хийлгэж, шийдвэрлэн ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын үйлчлүүлэгчийн санхүүгийн танилцуулсан болно. бүртгэлийг удирдлага, ажилтанд

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## 5 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 5.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	<i>/мянган төгрөгөөр/</i>	
	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>404,725,060.2</b>	<b>378,365,042.5</b>
Мөнгөн хөрөнгө	112,643,329.6	144,646,863.6
Богино хугацаат хөрөнгө оруулалт	8,000,000.0	7,099,995.8
Авлага	174,103,986.9	194,834,592.3
Урьдчилгаа	1,909,184.4	11,046,762.9
Бараа материал	20,174,566.4	20,705,399.4
Бусад эргэлтийн хөрөнгө	87,893,992.9	31,428.5
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>529,314,293.9</b>	<b>650,316,207.7</b>
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	100,000.0
Үндсэн хөрөнгө	529,314,293.9	650,216,207.7
Биет хөрөнгө	406,562,392.0	433,353,944.5
Биет бус хөрөнгө	122,751,901.8	127,665,911.2
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	89,196,352.0
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>934,039,354.0</b>	<b>1,028,681,250.2</b>
<b>Нийт өр төлбөр</b>	<b>40,424,484.4</b>	<b>64,816,007.7</b>
Богино хугацаат өр төлбөр	32,805,396.5	46,863,390.1
Урт хугацаат өр төлбөр	7,619,087.9	17,952,617.6
<b>Цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>893,614,869.6</b>	<b>963,865,242.5</b>
Засгийн газрын хувь оролцоо	893,614,869.6	963,865,242.5
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	174,898,285.0	174,898,285.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	32,003,869.0	31,001,965.8
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	2,315,269.4	2,315,269.4
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	2,495.3	103,426.8
Хуримтлагдсан үр дүн	516,654,849.8	588,660,888.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	167,740,101.0	166,885,407.2
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>934,039,354.0</b>	<b>1,028,681,250.2</b>



## 5.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,505,113,936.5</b>	<b>1,467,743,273.7</b>
<b>Татварын бус орлого</b>	<b>213,218,746.1</b>	<b>259,060,090.5</b>
Нийтлэг татварын бус орлого	205,081,586.4	253,891,975.3
Тусламжийн орлого	7,412,668.1	4,222,052.8
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	724,491.5	946,062.4
<b>Тусламж, санхүүжилтийн орлого</b>	<b>1,291,895,190.4</b>	<b>1,208,683,183.2</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,396,441,808.6</b>	<b>1,390,417,923.2</b>
<b>Урсгал зардал</b>	<b>1,385,713,153.2</b>	<b>1,370,519,284.7</b>
<b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>383,144,112.0</b>	<b>396,491,763.0</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	150,119,395.1	152,496,574.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,049,687.4	16,906,917.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,995,929.0	12,424,723.5
Хангамж, бараа материалын зардал	105,696,703.0	103,115,061.1
Нормативт зардал	1,579,698.7	1,491,843.8
Эд хогшил, урсгал засварын зардал	4,061,898.2	5,456,269.1
Томилолт, зочны зардал	3,203,417.0	3,532,831.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,139,874.4	36,524,130.6
Бараа үйлчилгээний бусад зардал	53,297,509.3	64,543,410.8
Хүү	135,692.6	246,239.1
Татаас	0.0	1,954.8
Урсгал шилжүүлэг	1,002,433,348.6	973,779,327.8
Хөрөнгийн зардал	10,728,655.4	19,898,638.5
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>108,672,127.8</b>	<b>77,325,350.5</b>
<b>Үйл ажиллагааны бус орлогын дүн</b>	<b>4,008,809.8</b>	<b>564,449.8</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,491,322.5</b>	<b>3,325,310.3</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>110,189,615.1</b>	<b>74,564,489.9</b>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

### 5.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*/мянган төгрөгөөр/*

Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/ өмч
<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>639,395,839.8</b>	-	<b>639,395,839.8</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	143,741,388.4	-	143,741,388.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	783,137,228.2	-	783,137,228.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	288,026.3	-	288,026.3
Тайлант үеийн үр дүн	110,189,615.1	-	110,189,615.1
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>893,614,869.6</b>	-	<b>893,614,869.6</b>
<b>2017 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>893,614,869.6</b>	-	<b>893,614,869.6</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,372,282.7)	-	(3,372,282.7)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	890,242,587.0	-	890,242,587.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,951,320.4)	-	(1,951,320.4)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(4,079.1)	-	(4,079.1)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	1,013,565.1	-	1,013,565.1
Тайлант үеийн үр дүн	74,564,489.9	-	74,564,489.9
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>963,865,242.5</b>	-	<b>963,865,242.5</b>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

#### 5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,521,953,550.4</b>	<b>1,422,276,774.1</b>
<b>Татварын бус орлого</b>	<b>229,937,473.4</b>	<b>236,317,857.2</b>
Нийтлэг татварын бус орлого	220,422,852.3	231,285,710.3
Тусламжийн орлого	8,790,129.6	4,102,594.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	724,491.5	929,552.9
<b>Тусламж, санхүүжилтийн орлого</b>	<b>1,292,016,077.0</b>	<b>1,185,958,916.9</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,274,335,407.6</b>	<b>1,254,157,775.2</b>
<b>Урсгал зардал</b>	<b>1,274,335,407.6</b>	<b>1,254,157,775.2</b>
Бараа, ажил үйлчилгээний зардал	270,274,936.1	285,239,153.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	150,693,441.7	152,203,439.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,781,688.1	17,431,877.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,777,644.9	11,761,025.1
Хангамж, бараа материалын зардал	7,797,300.7	10,961,006.5
Нормативт зардал	1,790,883.5	1,484,910.2
Эд хогшил, урсгал засварын зардал	5,400,186.0	5,629,493.3
Томилолт, зочны зардал	3,001,758.8	3,533,696.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,729,839.3	42,599,578.8
Бараа үйлчилгээний бусад зардал	35,302,193.1	39,634,126.7
Хүү	-	6,674.5
Татаас	-	1,954.8
Урсгал шилжүүлэг	1,004,060,471.5	968,909,992.4
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>247,618,142.7</b>	<b>168,118,998.8</b>
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн</b>	<b>11,318.2</b>	<b>29,899.7</b>
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн</b>	<b>201,215,682.3</b>	<b>114,840,286.0</b>
Хөрөнгийн зардал	201,215,682.3	114,840,286.0
Дотоод эх үүсвэрээр	201,215,682.3	114,117,234.5
Гадаад эх үүсвэрээр	-	723,051.5
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(201,204,364.1)</b>	<b>(114,810,386.4)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(30,901,451.2)</b>	<b>(21,305,078.5)</b>
Бусад эх үүсвэр	1,190,245.4	4,121,191.6
<b>Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл</b>	<b>30,981,996.9</b>	<b>22,704,155.2</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>	<b>1,109,699.7</b>	<b>2,722,114.9</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>15,512,327.4</b>	<b>32,003,534.0</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	97,131,002.1	112,643,329.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	112,643,329.6	144,646,863.6

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## 5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		6,406,927.3	(6,406,927.3)	
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,322,550,267.8</b>	<b>1,236,418,550.4</b>	<b>86,131,717.4</b>	<b>93.5</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,109,982,183.1</b>	<b>1,092,297,208.1</b>	<b>17,684,975.0</b>	<b>98.4</b>
<b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>135,704,279.2</b>	<b>120,936,584.4</b>	<b>14,767,694.8</b>	<b>89.1</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>47,966,562.0</b>	<b>47,034,445.0</b>	<b>932,117.0</b>	<b>98.1</b>
Үндсэн цалин	40,037,648.7	40,440,039.1	(402,390.4)	101.0
Нэмэгдэл	4,198,572.3	3,421,750.7	776,821.6	81.5
Унаа хоолны хөнгөлөлт	2,247,052.0	1,797,670.6	449,381.4	80.0
Урамшуулал	280,071.2	223,010.4	57,060.8	79.6
Гэрээт ажлын хөлс	1,203,217.8	1,151,974.2	51,243.6	95.7
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>5,652,658.6</b>	<b>5,168,615.9</b>	<b>484,042.7</b>	<b>91.4</b>
Тэтгэврийн даатгал	3,678,386.8	3,456,883.1	221,503.7	94.0
Тэтгэмжийн даатгал	500,002.1	384,787.9	115,214.2	77.0
ҮОМШӨ-ний даатгал	390,556.4	389,895.7	660.7	99.8
Ажилгүйдлийн даатгал	99,247.3	90,666.2	8,581.1	91.4
Эрүүл мэндийн даатгал	984,466.0	846,383.0	138,083.0	86.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,618,454.1</b>	<b>10,355,490.8</b>	<b>262,963.3</b>	<b>97.5</b>
Гэрэл, цахилгаан	1,882,153.0	1,932,876.6	(50,723.6)	102.7
Түлш, халаалт	7,056,652.1	6,730,792.1	325,860.0	95.4
Цэвэр, бохир ус	512,001.2	634,143.0	(122,141.8)	123.9
Байрны түрээс	1,167,647.8	1,057,679.1	109,968.7	90.6
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,891,759.8</b>	<b>5,564,698.0</b>	<b>327,061.8</b>	<b>94.5</b>
Бичиг хэрэг	231,830.2	223,074.1	8,756.1	96.2
Тээвэр, шатахуун	269,574.1	256,904.9	12,669.2	95.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	319,838.1	293,144.2	26,693.9	91.7
Ном, хэвлэл	4,493,193.2	4,231,743.8	261,449.4	94.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	34,670.6	27,956.7	6,713.9	80.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	542,653.6	531,874.3	10,779.3	98.0
<b>Нормативт зардал</b>	<b>165,884.8</b>	<b>164,972.8</b>	<b>912.0</b>	<b>99.5</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,060.3	1,844.2	216.1	89.5
Хоол, хүнс	94,318.6	94,274.1	44.5	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	69,505.9	68,854.6	651.3	99.1
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,302,135.4</b>	<b>1,271,560.3</b>	<b>30,575.1</b>	<b>97.7</b>
Багаж, техник, хэрэгсэл	718,624.0	689,546.0	29,078.0	96.0
Тавилга	4,978.1	4,767.3	210.8	95.8
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,737.0	4,273.8	1,463.2	74.5
Урсгал засвар	572,796.3	572,973.3	(177.0)	100.0
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>464,862.0</b>	<b>332,503.9</b>	<b>132,358.1</b>	<b>71.5</b>
Гадаад албан томилолт	37,008.9	736.3	36,272.6	2.0
Дотоод албан томилолт	427,005.5	331,767.6	95,237.9	77.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	847.6	-	847.6	0.0

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНХҮҮГИЙН ДҮГНЭЛТ

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын  
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>53,420,280.3</b>	<b>37,216,779.3</b>	<b>16,203,501.0</b>	<b>69.7</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,946,316.2	36,767,569.7	16,178,746.5	69.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	74,541.0	64,050.8	10,490.2	85.9
Даатгалын үйлчилгээ	44,680.8	43,865.9	814.9	98.2
Тээврийн хэрэгслийн татвар	14,725.9	11,141.8	3,584.1	75.7
Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,132.4	1,278.3	854.1	60.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	120,174.9	116,644.8	3,530.1	97.1
Газрын төлбөр	33,042.8	27,840.1	5,202.7	84.3
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,062.7	850.4	212.3	80.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	183,603.6	183,537.5	66.1	100.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,221,682.2</b>	<b>13,827,518.2</b>	<b>(3,605,836.0)</b>	<b>135.3</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	8,258,382.3	8,569,037.4	(310,655.1)	103.8
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,963,299.9	5,258,480.8	(3,295,180.9)	267.8
<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>974,277,903.9</b>	<b>971,360,623.8</b>	<b>2,917,280.1</b>	<b>99.7</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	945,636,551.6	943,572,192.3	2,064,359.3	99.8
Засгийн газрын дотоод шилжүүлэг	945,582,887.7	943,518,814.9	2,064,072.8	99.8
Засгийн газрын гадаад шилжүүлэг	53,663.9	53,377.4	286.5	99.5
Бусад урсгал шилжүүлэг	28,641,352.3	27,788,431.5	852,920.8	97.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	417,300.5	381,992.3	35,308.2	91.5
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,979,499.8	25,296,882.9	682,616.9	97.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	878,565.7	841,874.5	36,691.2	95.8
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	46,913.0	46,913.0	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,319,073.3	1,220,768.8	98,304.5	92.6
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>149,453,401.4</b>	<b>121,417,187.0</b>	<b>28,036,214.4</b>	<b>81.2</b>
Барилга байгууламж	83,911,384.6	76,674,023.9	7,237,360.7	91.4
Их засвар	13,315,275.5	13,016,198.6	299,076.9	97.8
Тоног төхөөрөмж	28,781,833.8	17,621,508.7	11,160,325.1	61.2
Бусад хөрөнгө	23,444,907.5	14,105,455.8	9,339,451.7	60.2
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>63,114,683.3</b>	<b>22,704,155.2</b>	<b>40,410,528.1</b>	<b>36.0</b>
Эргэж төлөгдөх зээл	63,114,683.3	22,704,155.2	40,410,528.1	36.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,322,550,267.8</b>	<b>1,241,967,714.4</b>	<b>80,582,553.4</b>	<b>93.9</b>
Улсын төсвөөс санхүүжих	1,241,181,458.9	1,190,184,670.5	50,996,788.4	95.9
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	76,365,436.0	47,881,808.7	28,483,627.3	62.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,496,570.7	4,191,165.5	305,405.2	93.2
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	476,800.5	521,290.0	(44,489.5)	109.3
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	71,392,064.8	43,169,353.2	28,222,711.6	60.5
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	5,003,372.9	3,901,235.2	1,102,137.7	78.0
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	5,003,372.9	3,901,235.2	1,102,137.7	78.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	11,822,468.7	(11,822,468.7)	-

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНД ДҮГНЭЛТ



Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын  
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Төсвийн бусад мэдээллийн ангилал	42,135.0	42,138.0	-3	100.0
Байгууллагын тоо	88	88	0	100.0
Ажиллагсадын тоо	4,397	4,387	10	100.0
Удирдах ажилтан	182	183	-1	101.0
Гүйцэтгэх ажилтан	3,375	3,379	-4	100.0
Үйлчлэх ажилтан	812	797	15	98.0

